



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот


“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын
балансад бүртгэлтэй барилгыг акталж,
данс бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 203 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/51 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн шүүхийн иргэний Давж заалдах шатны шүүхийн 2000 оны 414 дүгээр магадлал, Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 8260 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй 28,644,883.20 (хорин найман сая зургаан зуун дөчин дөрвөн мянга найман зуун наян гурван төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан барилгыг актлан, данс бүртгэлээсээ хасахыг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2022 оны 02 дугаар сарын 07
-ний өдрийн А/22 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖ

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Байршил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Тайлбар
1	Кузов цехийн барилга	1974	СБД-ийн 3 дугаар хороо хуучнаар "Автобус-3" компанийн хашаанд	28,644,883.20	13,367,612.16	15,277,221.04	Нийслэлийн шүүхийн иргэний Давж заалдах шатны шүүхийн 2000 оны 414 дүгээр магадлал, Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 8260 дугаар захирамжийн дагуу
Нийт				28,644,883.20	13,367,612.16	15,277,221.04	